



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 397

Улаанбаатар хот

“Мон сант алдар” ХЗХ-ны төсөл хөтөлбөрийг
дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх
зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ын 5 дугаар зүйлийн 5.8.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мон сант алдар” ХЗХ-ны төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд холбогдох тэмдэглэгээг 2015 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хийлгэхийг “Мон сант алдар” ХЗХ /М.Батмөнх/-нд үүрэг болгосугай.
3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, холбогдох өөрчлөлтийг Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

001056